

## УЧАСТИЕ МОНГОЛЬСКИХ ДЕЛЕГАТОВ В I СЪЕЗДЕ РЕВОЛЮЦИОННЫХ ОРГАНИЗАЦИЙ ДАЛЬНЕГО ВОСТОКА

(Резюме)

МНРП с самого начала своего образования установила тесные связи с международным коммунистическим движением. Наглядным примером этого является участие делегатов МНРП, молодежной и женской организаций Монголии в первом съезде Революционных организаций Дальнего Востока, который состоялся в начале 1922 г. в Москве. Делегаты в своих выступлениях и докладах коротко и с предельной ясностью ознакомили участников съезда с ходом и результатом длительной национально-освободительной борьбы монгольского народа против чужеземных поработителей и внутренних угнетателей, большой организаторской работой МНРП по развитию и углублению Народной революции, а также проводившимся в то время в стране революционно-демократическими преобразованиями.

В статье особое внимание уделяется анализу содержания докладов и выступлений, с которыми выступили делегаты революционной Монголии на съезде революционных организаций Дальнего Востока.

### **ДОРНОД ТУРКСТАНЫ АРД ТҮМНИЙ ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТЭМЦЛИЙН ТҮҮХЭЭС**

**М. Хурметхан**

Октябрийн социалист хувьсгалын үзэл санаа Дорнод Туркстаны ард түмнийг сэргээж, эрх чөлөө, нийгмийн дэвшлийн төлөө тэмцэлд босоход гуйлын их нөлөө үзүүлсэн юм.

Дорнод Туркстаны ард түмэн Оросын ард түмэнтэй аль хэдийнээс зүйл бүрийн холбоотой байсан нь Октябрийн хувьсгалын чөлөөлөх үзэл санаа Дорнод Туркстанд дэлгэрэхэд хамгийн тохиромжтой нөхцөл болжээ.

Октябрийн социалист их хувьсгалын шууд нөлөөгөөр Монгол оронд Ардын хувьсгалт ялсан нь хөрш зэргэлдээ Дорнод Туркстаны ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлтөд хувьсгалжуулагч нөлөө бас үзүүлсэн юм. Монголын Ардын хувьсгалын ялалт нь хоцрогдсон орнууд ялсан пролетарийн орны тусламжтайгаар эрх чөлөө, тусгаар тогтнолоо байлдан олж, нийгмийн дэвшлийн замаар хөгжиж болохын анхны бодит жишээг Дорнод Туркстаны ард түмэнд харуулсан юм.

Эдгээр бодит жишээг нүдээр үзсэн Дорнод Туркстан дахь уйгур, казах, монгол, узбек, киргиз, тажик, татар зэрэг ард түмэн үндэснийхээ эрх чөлөө, нийгмийн дэвшил хөгжлийн төлөө тэмцэлд зоригжин боссон түүхтэй билээ.

XX зууны 30—40 өөд онд тус нутгийн ард түмэн гоминданыхны үндэсний колончлох бодлого, нийгэм—эдийн засгийн дарлалд маш хүндээр өртсөн нь эрх чөлөөнийхөө төлөө зэвсэгт тэмцэлд босохын гол шалтгаан байв. Дорнод Туркстанд өрнөөсөн үндэсний эрх чөлөөний

хөдөлгөөнд хамгийн түрүүнд зүүн хойд нутгийн хөдөлмөрчид боссон юм. Энэ тухай Зөвлөлтийн эрдэмтэн Н. Н. Мингулов бичихдээ: «Ард түмний аж амьдрал туйлдаа хүртэл доройтсон Синьцеяны малчид оршин суудаг хойд районуудад (Алтай, Тарвагатай, Или), ардын ардчилсан хөдөлгөөн хамгийн их далайцтай өрнөсөн юм. Үүний шалтгаан бол нэгдүгээрт: малын хүнд албан татварыг нэмэгдүүлсэн явдал: хоёрдугаарт: ЗХУ-тай эдийн засгийн харилцааг тасалсан нь хойд зүгийн мал аж ахуй эрхэлсэн районууд хүндээр нөлөөлөв. Яагаад гэвэл ЗХУ-тай худалдааны харилцаа тасарсны улмаас тэд мал аж ахуйн бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлгүй болжээ.

Түүнээс гадна дээрх районуудад үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн хүчтэй өрнөхөд хувьсгалт нууц бүлгэмийнхний үйл ажиллагаа шууд нөлөөлсөн юм. Эдгээр бүлгэм нүүдэлчдийн дунд хувьсгалт сурталчилгааны их хэмжээний ажилыг явуулж ирсэн байна»<sup>1</sup> гэжээ.

Дорнод Туркстаны зүүн гурван тойргоос эхлээд Алтай аймгийн хөдөлмөрчид гоминданыхны эсрэг зэвсэгт бослого гаргажээ. Алтайд өрнөсөн хөдөлгөөний тухай уг тэмцлийг зохион байгуулагчдын нэг, цогт хувьсгалч Далелхан Сүкирбаев\* хожим бичихдээ: «30-аад онд засгийн эрхэнд гарсан Шэн Шицай улалгүй ард түмнээс урваж Чанкайшийгийнхний талд илээр орж, энэ тутагт фашист дэглэмийг тогтоожээ. Тэр удалгүй Дорнод Туркстаны ард түмнийг уусгах бодлогыг явуулж эхлэв. Түүнийг засгийн эрхэнд байхад шорон гяндан хүнээр пиг дүүрэв. Ард түмэн аллага хядлагад өртөв. Энэ хатуу дэглэмийг тэсэж ядан Алтай аймгийн ард түмэн 1940 оны 2-р сарын 2-нд уг дэглэмийн эсрэг «амьдрал, эсвэл үхэл» гэсэн уриан дор зохион байгуулалтгүйгээр бослогод гарав. Уг бослого бусад ард түмэнд маш их

1. Вопросы истории Казахстана и Восточного Туркстана, Труды института истории, археологии и этнографии им Ч. Ч. Валиханова. АН КазССР. А-А. 1962, с. 72.

\*. Далелхан Сүкирбаев ( 1940—1949 ) Дорнод Туркстанд өрнөсөн үндэсний эрх чөлөөний тэмцлийн нэрт зүтгэлтнүүдийн нэг, хошууч генерал, казах хүн юм. Цагаантны генерал Бакичийн цэрэг 1921 онд БНМАУ-ын Баян-Өлгий аймгийн нутагт орж дээрэм тонуул хийхэд тэдний эсрэг нутгийн хүмүүс босоход Далелхан идэвхтэй оролцжээ. 1939 онд Алтай аймгийн хөдөлмөрчид Хятадын харгис цэргийн эрхтнүүдийн эсрэг тэмцэлд босоход мөн идэвхтэй оролцсон байна. Тэр мөн 1940—45 онд Алтай аймагт өрнөсөн гоминданы эсрэг үндэсний эрх чөлөөний тэмцлийн нэг удирдагч байв. 1945 онд Алтай аймаг чөлөөлөгдсөний дараа Алтай аймгийн генерал губернаторын нэгдү гээр орлогч, мөн аймгийн цэргийн тойргийн жанжнаар томилогджээ. ДТБНУ байгуулагдах үед засгийн газрын гишүүн, үндэсний армийн ерөнхий командлагчийн нэгдүгээр орлогч (1946), дараа нь Алтай аймгийн хязгаарын жан жин ба Эрүүлийг хамгаалах яамны сайдаар ажиллаж байв. Түүнд «Ардын баатар» хүндэт цол олгожээ. 1949 оны 8-р сарын 27-нд онгоцны ослоор Далелхан Сүкирбаев амь үрэгджээ.

нөлөө үзүүлсэн билээ. Хамгийн түрүүнд энэ бослогыг Или районы ард түмэн дэмсэн юм»<sup>2</sup> гэжээ.

Дорнод Туркстаны Алтай аймгийн хөдөлмөрчид зэвсэгт бослогод гарахын шалтаг нь аймгийн удирдагчид ард түмний дунд асар их нэр хүндтэй Ж. Шарипхан\* ба бусад хүмүүсийг баривчилсан явдал байлаа. Мөн Шэн Шицай тус аймгийн Кокто-гай, Чингэл хошуунд цэрэг явуулан нутгийн нөлөө бүхий хүмүүсийг газар дээр нь баривчилж хүн амын гарт байсан зэр зэвсгийг хураан авав. Гоминданыхны иймэрхүү харгислал нь ард түмний уур хилэнг бадрааж зэвсэгт бослого гаргахад хүргэжээ.

Алтай аймгийн Коктогай хошуунаас Ирисхан Ногайбаев, Актеке баатар тэргүүтэй хүмүүс 1940 оны 2-р сард хошууны засаг захиргааг эзлэн авч шалгалтын комисс (хүн амыг нэгжиж, зэр зэвсгийг нь хурааж байсан гоминданы цэрэг-М. Х.)-ийг устгаж анхны амжилтанд хүрчээ.

Шэн Шицай босогчдыг залхаан цээрлүүлэх зорилгоор гоминданы 10 мянган цэргийг Алтайд явуулав.<sup>3</sup> Огт зэр зэвсэггүй босогчид гоминданы нисэх онгоц, танк, хуягт машин, пулеметоор зэвсэглэсэн давуу хүчтэй Шар нуур, Каратүнке, Сарытогай зэрэг газарт баатарлагаар тулалдав. Тулалдаанд босогчид 300 хүнээ алдсаны дотор зэвсэгт бослогын удирдагчид Ирисха, Актеке баатар, зуутын дарга-Закильбай, Дагестан, Сейтхан нар эрэлхэг зоригтойгоор тулалдаж амь үрэгдсэн юм.

А. Мин, Ростислов Петров нарын бичиж Алма-Ата хотод 1982 онд хэвлүүлсэн Алтай дахь абак-керейчүүдийн энэ үеийн амьдралын түүхийн тухай бичсэн «Хар эрчис» хэмээх роман—он дараалсан бичигт Алтай аймагт гарсан уг бослогыг явц болон гоминданы цэргүүд босогчдыг хэрхэн харгисласныг бодитой дүрслэн бичжээ.

Босогчид тэмцлээ баатарлагаар үргэлжлүүлж цаашид зохион байгуулалттай болжээ. 1944 оны 8-р сард Алтай аймгийн 5 районы 100 мянга орчим хүнийг гоминданыхнаас чөлөөлөв. Энэ үед тэмцэгчдийн эгнээ 5 мянга гаруй хүн болж, 9 том отряд, 1 ерөнхий штабт хамаарагдаж байв.<sup>4</sup>

Алтай аймгийн партизануудын амжилт нь Или, Тарвагатай нутгийн тэмцэгчдийг зоригжуулсан юм. Эдгээр нутагт үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг Кульджа хотод 1944 онд байгуулагдсан «Эрх чөлөөний холбоо», 1945 онд байгуулагдсан «Хувьсгалт ардчилсан нам», «Хувьсгалт залуучуудын эвлэл» зохион байгуулж байв.

2. Далелхан Сүкирбаев, «Алтай дахь хувьсгалт тэмцлийн тойм» «Эрх чөлөөт Алтай» хэвлэл (казах хэлээр) 1948 он. т. 5—6.

\*Шарипхан Женисханов. 1902 онд Алтай аймагт төрсөн. Казах, Шар сүм Урумч хотод суралцан боловсрол эзэмшсэн байна. Тэрээр 1931 онд Алтай аймагт ирж казахын хөдөлмөрчдийг Хятадын феодалуудын эсрэг тэмцэлд босгов. Уг тэмцэл 1933 оны 4-р сарын 12-нд ялалтаар төгсөж, тус мужид, (Синьцзян) ардчилсан чиглэлтэй засаг тогтоход Ж. Шарипхан тус засгийн гишүүн, Алтай аймгийн хязгаарын жанжнаар 1933—39 онд ажиллаж байжээ. Энэ үед Шарипхан тус нутгийн аж ахуй, соёл, боловсролыг хөгжүүлэх талаар маш их ажил хийв. Тэрээр ЗХУ-тай найрамдалт харилцааг хөгжүүлэх талар цуцалтгүй ажиллаж, их хөдөлмөр гаргасан санаачилгаар Урумчид казах, монгол, киргиз сурагчдын дотуур сургууль, казах-киргизийн соёлын нийгэмлэг байгуулагдан, уг ажилд өөрөө арми идэвхтэй оролцож байсан юм. «Алтай» сонин «Шинэ Алтай» сэтгүүлийг хэвлэн гаргах ажлыг зохион байгуулжээ. Шэн Шицай 1939 оны 8-р сард Ж. Шарипханыг баривчлан, 1942 онд Урумчид тамлан алжээ.

3 Казах совет энциклопедиясы А—А., 1976. т. I, б. 310 (казах хэлээр)

4 Мөн тэнд.

\*. А. Мин, Ростислав Петров. «Черный Иртыш» А—А., 1982.

1944 оны намар Дорнод Туркстаны Или аймгийн Нылки хошуунд Акпар, Гани, Фатиха, Сейт, Суанбек, Науан нарын удирдлагаар 500 хүнтэй партизаны отряд байгуулагджээ. Мөн оны 9-р сард партизанууд Нылки хошууны төвийг гоминданыхнаас чөлөөлөв. 1944 оны 10-р сард Кульджа хотод нууцаар ажиллаж байсан «Эрх чөлөөний холбоо» хотын хүн амыг зэвсэгт бослогод гаргахад Нылки хошууг чөлөөлсөн партизануудын гол хэсэг нь Кульджа хотод хүрэлцэн ирж гоминданы цэрэгтэй байлдаж, 1944 оны 11-р сарын 12-нд Кульджа хотыг гоминданы цэргээс бүрэн чөлөөлөв. Энэ тулалдаанд Искакбек Муниновын\* удирдсан 500 хүнээс бүрдсэн отряд дайсны сайтар зэвсэглэсэн 3 мянган хүнтэй цэргийн хүчийг бутцохиж<sup>5</sup> эрэлхэг зоригийн гайхамшигт жишээг үзүүлэв.

Кульджа хотыг чөлөөлснөөр зэвсэгт бослого нийт ард түмний шинжтэй болов. 1944 оны 11-р сарын эхээр тэмцэгчдийн төв штаб байгуулагдан, хувьсгалт түр засгийн газар байгуулах анхны алхам хийжээ. Ийнхүү Дорнод Туркстаны зүүн гурван аймгийн ихэнх нутаг, Ялангуяа Кульджа хот гоминданыхнаас бүрэн чөлөөлөгдсөн нь Дорнод Туркстаны Бүгд Найрамдах Улс (ДТБНУ)-ыг байгуулах нөхцөл бүрдүүлэв.

Ялалтанд хүрсэн уугуул нутгийн зэвсэгт тэмцэгчид 1944 оны 11-сарын 12-нд гоминданыхнаас чөлөөлөгдсөн Синьцзяны дэвсгэр нутагт Дорнод Туркстаны Бүгд Найрамдах Улс байгуулагдсаныг албан ёсоор зарлав. Тус Бүгд Найрамдах Улс байгуулагдсан явдал нь Синьцзяны дарлагдсан ард түмнээс харгис гоминданыхны эс-рэг явуулсан зэвсэгт тэмцлийн гол үр дүн байлаа.

ДТБНУ-ын хувьсгалт түр засгийн газар Кульджа хотод байрлав. Дорнод Туркстаны хувьсгалт түр засгийн газар нь цэргийн дотоод явдлын, ард түмний хэрэг эрхлэх, улсын хэрэг эрхлэх, ардын боловсрол, газар тариалангийн зэрэг, яам, ардын дээд шүүх, хяналт шалгалтын улсын хорооноос бүрдэж байв.<sup>6</sup> Или, Алтай, Тарвагатай гурван аймгийн байгууллага, 24 ардын комиссарит байгуулав. Хагас сар хүрээлсэн улаан таван хошуутай, голд нь ногоон зурвастай ДТБНУ-ын туг батлагджээ.<sup>7</sup>

ДТБНУ-ын засгийн газар нь нийт Синьцзяны засгийн газар байх бөгөөд тус нутгийн ард түмний үндэсний чөлөөний хөдөлгөөний удирдлагыг өөрийн гартаа авсныг түр засгийн газар мэдэгджээ. ДТБНУ байгуулагдсаныг Синьцзяны Хятад биш ард түмэн маш ихээр талархан угтсан бөгөөд энэ нь Синьцзян дахь уйгар, казах, монгол, киргиз, узбек зэрэг ард түмний түүхэнд гарсан чухал үйл явдал байв.

Дорнод Туркстаны Бүгд Найрамдах Улс нь есөн зүйл бүхий анхны программ батлан, түүндээ «Дорнод Туркстанд оршин суудаг хүн ам,

\*Искакбек Мунинов. (1902—1949), Дорнод Туркстанд өрнөсөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нэрт удирдагчдын нэг. Кашгарын Үчтурфан тосгонд ядуу тариачны гэр бүлд төрсөн. Киргиз, Тэрээр 1922—1924 онд ЗХУ-д (Киргиз-д) суралцсан нь түүний амьдралд онцгой чухал нөлөө үзүүлсэн юм. 1932 онд Ташкуртан, Улугчатад гарсан бослогыг удирдсан учир 1939 онд гоминданыхан түүний баривчлах гэсэн боловч бүтээгүй юм. 1944 онд гоминданы эсрэг тэмцэлд И. Мунинов онцгой гавьяа байгуулсан юм. 1945 онд ДТБНУ-ын засгийн газар түүнд хошууч генерал цол олгож, үндэсний армийн ерөнхий жанжнаар томилов. 1949 оны 8-р сарын 27-нд онгоцны ослын улмаас амь үрэгджээ. 5. Л. Бадамамов. Казахи Восточного Туркстана в национально-освободитель ном движений против гоминдановской клики Чан Кайши (1940—1949) А—А. 1967. с. 29. 6. Д. Бадамамов. Казахи Восточного Туркстана в национально-освободительном Движении против гоминдановской клики Чан Кайши (1940-1949), АНА. 1967. с. 30. 7 «Десять лет в Синьцзяне» Ланьчжоу. 1957, с. 80 .

ард түмний тэгш эрхийн үндсэн дээр чөлөөтэй, биеэ даасан бүгд найрамдах улсыг байгуулах: ЗХУ-тай найрамдал тогтоон, аж үйлвэр, хөдөө аж ахуйг хөгжүүлэх, хүн амын аж байдлыг дээшлүүлэх, соёл боловсрол, эрүүлийг хамгаалах явдлыг хөгжүүлэх, ДТБНУ-ын үндэсний армийг байгуулахыг заасан байна».<sup>8</sup> Уг программыг биелүүлэх анхны алхам нь үндэсний армийг зохион байгуулах ажлаас эхэлж, бусад хувьсгалт олон арга хэмжээг нэгэн зэрэг хэрэгжүүлж байв.

1945 оны 2-р сарын 3-нд ДТБНУ-ын хувьсгалт түр засгийн газрын тэргүүлэгчдийн 19-р хурлаар ДТБНУ-ын үндэсний армийг байгуулах шийдвэр гарган, армитай холбогдол бүхий бусад асуудлыг хэлэлцжээ. ДТБНУ-ын армийн ерөнхий жанжнаар хошууч генерал Искакбек Мунинов орлогчоор нь хошууч генерал Зунун Тайпов\* болон цэргийн удирдлагад бусад хэд хэдэн хүн томилогджээ. 1945 оны 4-р сарын 8-нд ДТБНУ-ын Кульджа хотын төв талбайд цэргийн ёслолын жагсаал болж, түр засгийн газрын удирдагчдын өмнүүр явж өнгөрсөн байна. Мөн өдөр үндэсний арми байгуулагдсаныг албан ёсоор зарлан тунхаглаж, армийн тугийг гардуулан өгөөд, энэ өдрийг ДТБНУ-ын үндэсний арми байгуулагдсан өдөр болгон тогтжээ. Үндэсний армийн бүрэлдэхүүнд Суйдун, Или, Текесийн морьт цэргийн хороо, Консайн хороо зэрэг анги салбарууд орж, нийт 13 мянган цэрэг офицертэй байжээ.<sup>9</sup> Цаашид үндэсний армийн эгнээ хурдан өсч, удалгүй 30 мянган цэрэг, офицертэй болсон байна.

1945 оны 8-р сард үндэсний армийн цэрэг нутгийн партизануудын хамт Тарвагатай аймгийг дайснаас чөлөөлжээ. Гурван аймгийн тэмцэгчдээс олон жил-ийн турш харгис гоминданы эсрэг явуулсан тэмцэл нь 1945 оны 9-р сарын 6-нд гоминданы их хэмжээний цэрэг байрласан Шар сүм (одоогийн Алтай) хотыг гоминданы цэргээс чөлөөлсөн амжилтаар дуусчээ. Тус хотыг эзлэх тулалдаанд Дорнод Туркстаны цэрэг гоминданы 40 мянга илүү цэргийг олзолсны дотор хурандаа генерал Ван Сычжан, амбан сайд Гао Байо зэрэг гоминданы нам, захиргааны 152 хүн байв.<sup>10</sup> Тус хотыг эзлэх тулалдаанд дайсны 2000 цэргийг зэр зэвсгийн хамтаар ердөө 30 хүрэхгүй хүнтэй Далелхан Сүкирбаев их зориг гарган буулгаж авчээ. Энэ гавъяаг нь тэмдэглэн Далелхан Сүкирбаевт хошууш генерал цол олгон, түүнийг ДТБНУ-ын үндэсний армийн ерөнхий командлагчийн нэгдүгээр орлогчоор томилсон юм.<sup>11</sup>

ДТБНУ-ын түр засгийн газар өөрийн нутгийн аюулгүй байдлаа хамгаалахын тулд армийн хүч чадлыг улам бэхжүүлснээр 1945 оны 10-р сард ДТБНУ-ын зэвсэгт хүчний 40 мянган цэрэг, офицертэй

8. БНХАУ-ын үндэсний районууд дахь маогийнхны их гүрний бодлого УБ ., 1978, т. 48.

\*Зунун Тайпов. Дорнод Туркстанд өрнөсөн үндэсний эрх чөлөөний төлөө хөдөлгөөний удирдагчдын нэг. Хошууч генерал. Уйгур, ДТБНУ-ын үед Дорнод Туркстаны үндэсний чөлөөлөх армийн ерөнхий командлагчийн орлогчоор ажиллажээ. БНХАУ байгуулагдсаны дараа янз бүрийн албан ажил хийж байв. Тухайлбал, 1950—1960 онд Синьцзяны цэргийн тойргийн даргын орлогчоор ажиллаж байжээ. Түүнд 1955 онд БНХАУ-ын засгийн газрын шийдвэрээр хошууч генерал цол олгов. Улмаар маогийнхан үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд оролцогчдыг мөрдөн мөшгөж эхлэхэд Зунун Тайпов аргагүйн эрхэнд 1961 онд ЗХУ-д очсон юм. 1977 онд «Дорнод нутагт» хэмээх номоо уйгур хэлээр бичиж хэвлүүлэн, түүндээ өөрийн амьдрал, тэмцлийн замыг сонирхолтойгоор өгүүлжээ.

9. З. Теийпов. «Шарки Туркстан йериде» («Дорнод Туркстаны нутагт», (уйгур хэлээр), АНА. 1977, с. 110.

10. Казах совет энциклопедисы (казах хэлээр) т . I. А-А. 1976. с. 310.

11. З. Теийпов. Шарки Туркстан йериде А-А . 1977. с. 114.

болж, армийн зэвсэглэлд янз бүрийн 40 мянган буу, 1000 гаруй пулемёт 70 минометоос гадна хуягт машин 1, танк 3, нисэх онгоц 4-тэй байв.<sup>12</sup>

ДТБНУ-ын арми нь ард түмний хүсэл зоригийг илэрхийлж байсан учир хүчтэй байв. Үндэсний армийн цэргүүд 1945 оны намар зүүн гурван аймгийг бүхэлд нь дайснаас чөлөөлөн Урумчи хот руу давшин Манас голд тулж ирэв. Энэ байдал нь Урумчи дахь гоминданыхны ноёрхолд бодит аюулыг бий болгожээ. Энэ үед Урумчи дэх гоминданыхан ДТБНУ-ын хил дээр Хятадаас зэвсэгт хүчний 12 бригадыг ирүүлжээ. Зүүн гурван аймгийн хувьсгалт хүчийг устгахын тулд гоминданы 100 мянган цэрэг энд байрлаж байв.<sup>13</sup> Өөрийн байр суурийг Синьцзянд хадгалахын тулд Чан Кайши найрамдлын хэлэлцээ, хэрэв шаардлагатай бол зарим нэг буулт хийхэд бэлэн байгаагаа мэдэгдэж ДТБНУ-ын төлөөлөгчидтэй холбоо тогтоохыг генерал Чжан Чжедунд даалгажээ. ДТБНУ-ын төлөөлөгчид энх тайвны хэлэлцээний тухай гоминданыхны саналыг зөвшөөрөхдөө «Хятадад бүрэн тогтож байсан дотоод улс төрийн байдлын ерөнхий шинж, ХКН-ын улс төрийн чиг шугамд нийцүүлэн» хүлээн авчээ.<sup>14</sup>

ДТБНУ-ын төлөөлөгчид уг хэлэлцээг байгуулахдаа чухам ямар чиг шугам баримталж байсныг тайлбарлан зөвлөлтийн Хятад судлагч эрдэмтэн Т. Р. Рахимов бичихдээ: «Хятадад, түүнчлэн Синьцзянд үндэсний асуудлыг марксизм—ленинизмийн зарчмын үндсэн дээр шийдвэрлэх ёстой Хятадын ард түмний ардчилсан хувьсгал ялах болтол энх тайвны хэлэлцээ нь зүүн хойд гурван аймагт Синьцзяны ард түмний хувьсгалт ололтыг хамгаалан бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэж тэд тооцоолж байв. Үүнтэй холбогдон уйгур болон синьцзяны дарлагдсан бусад ард түмэн хувьсгал ялсны дараа БНМАУ-тай адил төрийн бие даасан, тусгаар тогтносон хэлбэрээр буюу эсвэл ЗХУ-ын холбооны бүгд найрамдах улстай адил төрийн хэлбэрийг олж авна гэдэгт ДТБНУ-ын төдөөлөгчид итгэл төгс байсныг илэрхийлж байсан юм»<sup>15</sup> гэжээ.

Хоёр талын хооронд завсарлагаатайгаар 8 сар үргэлжилсэн хэлэлцээний эцэст 11 зүйлтэй энх тайвны хэлэлцээрт 1946 оны 6-р сард гарын үсэг зурав. Уг хэлэлцээрийг бэлтгэж явуулахад Ахмеджан Касими\* их үүрэг гүйцэтгэжээ.

Энх тайвны хэлэлцээрээр Синьцзяны орон нутгийн засаг захиргааны байгууллагуудыг сонгуулиар байгуулах, үндэсний соёл боловсрол, хэлний хөгжлийн чөлөөт байдал, хэвлэн нийтлэх, хурал хийх, үг хэлэх, үндэсний цэргийн анги хэсгийг байгуулах зэрэг болон 25

12. Мөн тэнд.

13. Л. Бадамамов. Казахи восточного Туркстана... А-А. 1967. с. 30.

14. БНХАУ-ын үндэстний районууд дахь маогийнхны их гүрний бодлого. УБ., 1978. Т. 50.

15. З. Тейпов. Шарки Туркстан йериде А—А, 1977. с. 9.

Ахмеджан Касими (1911—1949) Дорнод Туркстан дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний гарамгай удирдагч, Талдыкурбан мужийн Панфилов хошуунд ядуу тариачны гэрт төржээ. Уйгур, Дээд боловсрол Хувьсгалт хөдөлгөөнд оролцсоны улмаар 1942 онд гоминданы засгийн газар Синьцзянд түүнийг шоронд хорив. 1944 онд шоронгоос оргож гараад Или аймаг дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнтэй нийлэв. Тэр жил Кульджа хотод хувьсгалт нууц байгууллага зохион байгуулав. ДТБНУ байгуулагдсаны дараа түүний албан ёсны төлөөлөгчийн хувьд Урумчи дэх Гоминданы засагтай хэлэлцээ хийв. Тэрээр 1948 онд Кульждад «Синьцзянд эрх чөлөө, ардчиллыг хамгаалах холбоо» нэртэй хувьсгалт байгууллага зохион байгуулав. Тэр холбооны бүх синьцзяны анхдугаар их хурлаар А. Касими тус холбооны даргаар сонгогджээ. 1949 оны 8-р сарын 27-нд А. Касими онгоцны ослын улмаас амь үрэгджээ.

хүний бүрэлдэхүүнтэй Синьцзяны эвслийн засгийн газар байгуулахыг заасан юм. Синьцзяны эвслийн засгийн газрын даргаар Чжан Жижун, орлогч даргаар Ахмеджан Касими, Бурхан Шахиди нар томилогдов. Уг хэлэлцээрийн дагуу ДТБНУ-ын түр засгийн газрыг татан буулгасан тухай зарлав. Мөн ДТБНУ-ын үндэсний армийн тоог гуравны нэгээр хорогдуулахаар зааж (11—12 мянга хүртэл) түүний 6 хороог Или, Алтай, Тарвагатайд тараан байрлуулав.

Гэвч удалгүй гоминданыхан энх тайвны хэлэлцээрийн заалтыг зөрчиж эхлэв. Эвслийн засгийн газрын бүрэлдэхүүнд орсон урьдах ДТБНУ-ын Ахмеджан Касими тэргүүтэй төлөөлөгчид арга буюу эвслийн засгийн газрын бүрэлдэхүүнээс гарч 1947 оны 8-р сарын 26-нд Кульджа хотод буцаж ирэв.

Ийнхүү энх тайвны хэлэлцээр зөрчигдсөн явдал нь синьцзяны ард түмэн гагцхүү харгис гоминданы ноёрхолыг устгасны үр дүнд эрх чөлөөгөө олж болохыг тод харуулав.

1948 оны зун Кульджа хотод хуралдсан ардчилсан байгууллага болон бүлгэмийнхний төлөөлөгчдийн бага хурлын дагуу Синьцзянд энх тайван, ардчиллыг хамгаалах холбоог байгуулж, холбооны даргаар Ахмеджан Касимиг сонгов. Холбооны гүйцэтгэх хорооны гишүүнээр Искакбек Мунинов, Далелхан Сүкирбаев, Абдукарим Аббасов\* нийт 29 хүн, орлогчоор 5 хүнийг тус тус сонгов.<sup>16</sup> Улс төрийн энэ байгууллагын гол зорилго нь Синьцзяныг харгис гоминданы ноёрголоос бүрэн чөлөөлөх, ардчилсан чиглэлтэй шинэ засгийг байгуулах явдал байлаа. «Синьцзянд энх тайван, ардчиллыг хамгаалах холбоо»-ны 12 зүйлт программ батлагдаж, уг холбооны эцсийн зорилго нь Синьцзянд социализм байгуулах явдал болохыг тодорхойлжээ. Холбооны 3 аймгийн 27 хошуу, орон нутгийн 755 анхан шатны байгууллага ажиллаж,<sup>17</sup> эгнээнд нь 80 мянган хүн багтаж байлаа.<sup>18</sup> «Синьцзянд энх тайван, ардчиллыг хамгаалах холбоо» программдаа тодорхойлсон зүйлийг амьдралд хэрэгжүүлэх талаар их ажил хийсэн юм. Уг холбоо нь «Алга» («Урагшаа») сонин «Одак», («Холбоо») сэтгүүлийг хэвлэн гаргаж байв.

Хятадад ардын хувьсгал ялсан нь Синьцзяны улс төрийн байдлыг өөрчлөв. 1949 оны 10-р сард Синьцзяны нутаг дэвсгэрт Хятадын Ардын Чөлөөлөх Арми (ХАЧА)-ийн ангиуд оров. ХАЧА-ийн цэрэг Синьцзянд орохоос өмнө ХКН-ын удирдлага дахь үндсэрхэг үзэлтнүүд гурван аймгийн хувьсгалчидтай холбоо тогтоох бүрэн боломжтой байсан боловч тийм холбоо тогтоохыг хүсээгүй юм. Синьцзянд байрлаж байсан гоминданы цэрэг Хятадын ардын чөлөөлөх армийн тушаалаар ХАЧА-ийн бүрэлдэхүүнд оров. Мөн тушаалаар 1945 оны 4-р сарын 8-нд байгуулагдсан ДТБНУ-ын үндэсний армийг 1950 оны 1-р сарын 10-нд бас ХАЧА-ийн бүрэлдэхүүнд нийлүүлэв.

\*Абдукарим Аббасов. (1920—1949) Дорнод Туркстан дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний гарамгай удирдагчдын нэг. Пржевалск хотод төрсөн. Уйгур. 1938 онд Синьцзяны дээд сургуульд суралцаж байхдаа марксизм ленинизмийн үзэл санааг идэвхтэй дэлгэрүүлж байв. 1942 онд түүнийг гоминданыхан баривчилсан юм. 1944 онд Сауан гэдэг хорих лагериас оргон гарч Или аймаг дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний тэмцэгчидтэй нийлжээ. 1946 онд Дорнод Туркстаны хувьсгалт залуучуудын эвлэлийг зохион байгуулахад оролцов. Синьцзян дахь ардын хувьсгалт намыг удирдаж байв. 1946 онд Синьцзяны эвслийн засгийн газрын гишүүн, нарийн бичгийн дарга нарын орлогчоор томилогдов. 1949 оны 8-р сарын 27-нд онгоцны ослын улмаас амь үрэгджээ.

16. Л. Бадамамов. Казахи Восточного Туркстана А – А. 1967, с. 36.

17. Казах совет энциклопедиясы. Т — 12. А — А, 1978, б. 328.

18. З. Тейипов. Шарки Туркстан йериде. А — А. 1977. с. 127.

1949 оны 12-р сард Бурхан Шахиди\* толгойлсон засгийн газар Синьцзянд байгуулагдав.

Дорнод Туркстаны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний гарамгай удирдагч Ахмеджан Касими, Далелхен Сүкирбаев, Искакбек Мунинов, Аудукарим Аббасов зэрэг хүмүүс Бээжингийн урилгаар БНХАУ-ыг тунхагласан Бүх Хятадын Улс Төрийн Зөвлөлдөх Зөвлөлийн анхдугаар чуулганд оролцохоор морджээ.

1949 оны 8-р сарын 27-нд тус төлөөлөгчдийн суусан нисэх онгоц осолд орж цөмөөрөө амь үрэгдсэн юм. Тэд Синьцзяны дарлагдсан ард түмний үндэсний эрх чөлөө, ардчилсан хөгжлийн төлөө тэмцэлд бүхий л амьдралаа зориулан асар их гавьяа байгуулсан хүмүүс байлаа. Дорнод Туркстаныг ардын ардчилсан улс болгон цэцэглүүлэн хөгжүүлэхийг тэд хүсэн мөрөөдөж байсан юм.

Ахмеджан Касими, Далелхан Сүкирбаев, Искакбек Мунинов, Абдукарим Аббасов синьцзяны олон угсаатан ард түмнийг үндэсний эрх чөлөө, аз жаргалын төлөө амь бие хайргүй эрэлхэг зорилготой тэмцэгчид байсан бөгөөд ЗХУ, БНМАУ-д найрсаг сэтгэлээр хандаж, үндэсний асуудлыг шийдвэрлэхдээ социализмын орнуудын туршлагыг авч хэрэглэхийг эрмэлздэг байжээ.

Сүүлд нь маоистууд 1944-49 онуудад үндэсний эрх чөлөөний төлөө гоминданы эсрэг тэмцэгчдийг «хятадуудын эсрэг тэмцсэн» гэж яллан устгасан билээ. Хятадад өрнөсөн дараагийн улс төрийн кампаниуд, ялангуяа «соёлын хувьсгал» нь урьдах ДТБНУ-ын нутаг дэвсгэрт асар их гай зовлон болж туссан нь нийтэд тодорхой билээ. Одоо үед ч гэсэн Синьцзян дахь хятад биш олон угсаатан ард түмэн өнгөрсөн үеийн тэмцлийн түүхээс сургамж авч, эрх чөлөө, аз жаргалант амьдралынхаа төлөө их хан үндэстний дээрэнгүй бодлогын эсрэг тэмцлээ үргэлжлүүлсэн хэвээр байна.

\*Бурхан Шахиди. (1894 онд төрсөн). Синьцзян мужийн нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн. Татар гэр бүлд төржээ. 1956 оноос БНХАУ -ын Синьцзян мужийн ардын засгийн газрын дарга, 1954—66 онд БХУТЗЗ -ийн Төв Хорооны даргын орлогч, Хятад дахь лалын шашны нийгэмлэг, Хятад Арабын найрамдлын нийгэмлэгийн дарга байв. 1955 онд БНХАУ -ын ШУА-ийн хятад биш ард түмнүүдийн хэлийг судлах хүрээлэнгийн захирал байв. 1966 онд Бурхан Шахиди «соёлын хувьсгал»-д хэлмэгдэв. Түүний хувь заяа удаан хугацаагаар тодорхойгүй байгаад сүүлд цагаатгагджээ. Одоо БХАУТЗЗ-ийн хорооны орлогч дарга, хятадын исламын шашны нийгэмлэгийн хүндэт дарга юм. Бээжинд амьдардаг.

## ИЗ ИСТОРИИ ОСВОБОДИТЕЛЬНОЙ БОРЬБЫ НАРОДОВ ВОСТОЧНОГО ТУРКЕСТАНА.

(Резюме)

Освободительные идеи Великой Октябрьской Социалистической революции оказали огромное влияние на судьбы народов Восточного Туркестана, подняв их на борьбу за социальное национальное освобождение. Победа народной революции в Монголии под влиянием Великого Октября также содействовала росту освободительной борьбы народов Восточного Туркестана. В статье автор освещает справедливую борьбу народов Восточного Туркестана в 30-40-ых годах XX в., за национальное освобождение в форме вооруженного восстания против господства реакционной гоминьдановской клики. Именно восстание народов Восточного Туркестана в 40-х гг. привело к провозглашению Восточно-Туркестанской республики, которая предприняла ряд важных революционно-демократических мер, направленных на социальный прогресс народов данного района. Существование Восточно-Туркестанской республики в определенной степени также способствовало победе народной революции в Китае.

Представители Восточно-Туркестанской республики, как подчеркивает автор статьи, идя на перемирие с гоминьдановцами, прежде всего, рассчитывали упрочить революционную базу в трёх Восставших округах Синьцзяна. Однако, грубое нарушение гоминьдановцами условий мирного соглашения вынудило представителей Восточно-Туркестанской республики выйти из состава коалиционного правительства Синьцзяна.

В 1948 году демократические силы Синьцзяна создали «Союз защиты свободы и демократии». В статье подробно описывается деятельность этого союза, задачей которого было освобождение Синьцзяна от реакционного гоминьдановского режима и создание демократического правительства.

В заключении статьи автор отмечает значение революционной борьбы народов Восточного Туркестана в 40-х годах, тесно увязывая ее с борьбой неханьских народностей Синьцзяна в настоящее время против великоханьской шовинистической политики китайского руководства.